



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 07 өдөр

Дугаар А/224

Номгон

Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх
тэргүүлэх чиглэл батлах тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, Жижиг, дунд, үйлдвэр үйлчилгээг дэмжих тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, Засгийн газрын 2019 оны 190 дүгээр тогтоол “Жижиг, дунд үйлдвэрийн тэргүүлэх ач холбогдол бүхий салбарын жагсаалт”, Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.5, 3.5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймаг, орон нутгийн түүхий эд, нөөц боломж давуу талд түшиглэсэн үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлж сумдад тулгамдсан асуудлыг шийдвэрлэж хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийг оновчтой зохион байгуулж жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхэлсэн аж ахуйг шинээр байгуулж үйлдвэрлэлийг өргөтгөхөд дэмжлэг үзүүлэх зорилгоор жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан жагсаалтын дагуу үйлдвэр үйлчилгээг хөгжүүлж, хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр дэмжин, төр хувийн хэвшлийн түншлэлд суурилан хөгжүүлж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Т.Хишигбаатар), Хүнс, хөдөө аж ахуйн газар (У.Балжинням), Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорац (Н.Баярсайхан), сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.


ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

601220297

Аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар
сарын 07-ны өдрийн А/24 дүгээр захирамжийн
хавсралт



**БАЯНХОНГОР АЙМАГТ 2024 ОН ХҮРТЭЛ ЖИЖИГ ДУНД
ҮЙЛДВЭРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ТЭРГҮҮЛЭХ
ЧИГЛЭЛИЙН ЖАГСААЛТ**

- 1.Газар тариалан
- 2.Мал, амьтны тэжээл тариалалт, үйлдвэр
- 3.Арьс шир боловсруулах
- 4.Мах, махан бүтээгдэхүүн дайвар бүтээгдэхүүн боловсруулах
- 5.Сав баглаа боодол үйлдвэрлэх
- 6.Оёмол бүтээгдэхүүн үйлдвэрлэх
- 7.Экспортод чиглэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх
- 8.Эрчимжсэн аж ахуй
- 9.Мал аж ахуйн гаралтай түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн нэгдсэн тогтолцоо /Загвар хоршоо/
- 10.Аялал жуулчлал
- 11.Орон нутгийн онцлог бэлгийн багц
- 12.Ахуй үйлчилгээ

_____оОо_____